



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 88

Хэрлэн сум

Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 84 дүгээр зарлигаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын 2.1, 2.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын арга хэмжээг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Хэнтий аймагт зохион байгуулсугай.

2.Тангараг өргөх ёслолын арга хэмжээг хариуцан зохион байгуулах албан тушаалтнаар Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга С.Бат-Эрдэнийг томилсугай.

3.Тангараг өргөх ёслолын арга хэмжээний хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

4. Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын арга хэмжээг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж ажиллахыг Салбар зөвлөлийн гишүүн С.Бат-Эрдэнэ, Нарийн бичгийн дарга Ж.Саруултөгс нарт даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА